



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/554

Хэрлэн сум

Х.Мөнхцэцэгт дохионы хэлний багшаар
суралцахад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3 дахь заалт аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 3 дугаар сарын 03-ны 10 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхэд хөгжил, хамгааллын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд дохионы хэлний сургагч багшаар бэлтгэгдэж буй Х.Мөнхцэцэгт 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.


2.Дэмжлэг олгох зардлын хуваарийг хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний "Хүүхэд хамгаалах жилийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал"-аас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны... дүгээр сарын...-ны дугаар захирамжийн хавсралт

Дэмжлэг үзүүлэх хуваарь

№	Зардлын нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Дэмжлэг үзүүлэх хугацаа	Бүгд үнэ
1	Суралцах хугацааны санхүүгийн дэмжлэг	3	500,000	1. 2022 оны 11 дүгээр сар 2. 2022 оны 12 дугаар сар 3. 2023 оны 1 дүгээр сар	1,500,000
Нийт					1,500,000